

2025 оны 6-р сарын 3-6-нд Бутан улсын Тимпу хотод зохион байгуулах “**Шинжлэх ухаан, Майндфүлнэсс ба Бясалгал**” олон улсын Очирт хөлгөний бага хурал

Бутан болон Үндэсний Аз Жаргалын Судалгааны Төв нь 2025 оны 6-р сарын 3-6-ны өдрүүдэд Бутан улсын Тимпу хотод “Шинжлэх ухаан, Майндфүлнэсс ба Бясалгал” сэдвийн хүрээнд бясалгалын дадал, шинжлэх ухааны судалгааны ололтын огтлолцлыг танилцуулах зорилготой олон улсын бага хурлыг зохион байгуулахаа баяртайгаар зарлаж байна. Энэхүү арга хэмжээ нь философич, оюун санааны дадалтан, хамба лам нар, шинжлэх ухааны олон салбарын эрдэмтэд, мөн бясалгалын мэргэжилтнүүдийн өөрсдийн өргөн мэдлэгээ солилцох шинэлэг уулзалт байх болно. Энэ нь Очирт хөлгөний талаар голлон хэлэлцдэг хурал бөгөөд 5 дахь удаагаа зохион байгуулагдаж байна. Бясалгал, майндфүлнэсс болон сэтгэлийг хувиргах арга техникууд нь өөр өв уламжлалд ч нэгэн адил оршдог тул хурлын үр өгөөжийг нэмэх Африк, Латин Америк, Австрали, Евро-Азийн иргэний, шашны болон уугуул нутгийн соёл уламжлалын талаар олон тооны илтгэлүүдийг хийхээр зорьж байгаа билээ.

Дөрвөн өдөр үргэлжлэх хурлын үеэр уг сэдвийн хүрээнд цуврал үзүүлэн болон илтгэлүүд зохион байгуулагдах болно. Бясалгал болон майндфул амьдралын дадалтай холбоотой практик сургалтуудыг мэргэжилтнүүд танилцуулна. “Шинжлэх ухаан, Майндфүлнэсс ба Бясалгал” хурлын илтгэлийн сэдвүүдийг дараах байдлаар харуулав. Гэхдээ хурлын агуулгатай холбоотой бусад сэдвүүдийг ч мөн адил хүлээн авна.

Мэдрэл судлал судалгаа: Мэдрэлийн уян хатан чанар ба бясалгалын дадлууд; бясалгалын техникуудын мониторинг (EEG, fMRI); тархины хоёр тал бөмбөлөгийн уялдаа холбоонд үзүүлэх бясалгалын нөлөө; тархинд бясалгалыг шингээн авах үе шатны зураглал; хүрд болон тарнийн бясалгалын эрдэм шинжилгээний судалгаа; бясалгал ба мэдрэлийн тогтолцоо; дотоод эрч хүчийг үүсгэх амьсгал ба бясалгал.

Хиймэл оюун ухаан (AI): Бясалгалын судалгаа болон сургалт дахь технологийн инноваци; Апп-уудын тусламжтай бясалгалын үр дүн; загварчилсан бясалгал дахь виртуал бодит байдлын(VR) боломж; дадлуудын биометрийн мониторинг ба нейробиологийн эргэх холбоо; бусад эзотерик дадлын эрдэм шинжилгээний нотолгоо.

Соёл, түүхийн сэдэв: Буддын бясалгал бусад соёлд үзүүлсэн нөлөө болон эсрэгээрээ; буддын нууцлаг бясалгал ба Хатха йогийн харьцуулсан судалгаа; өөр өөр нөхцөлд, түүний дотор өрнөд, дорнодод, майндфүлнэссд хандах хандлага; ялгаатай соёлуудад бясалгалын ач холбогдол; бясалгалын үүсэл ба үндэс суурь, ухамсарт нийгэм ба нийгмийн патологийг бууруулах, зохион байгуулалт ба манлайлал майндфүлнэсс ба бясалгалтай болон бясалгалгүйгээр.

Сэтгэл зүйн болон танин мэдэхүйн нөлөө: бясалгал эрүүл мэндэд; майндфүлнэсс, бүтээлч байдал ба инновацийн хоорондын холбоо; майндфүлнэсс, бясалгалын аз жаргалд үзүүлэх нөлөө; сэтгэл хөдлөлийн оюун ухааныг хөгжүүлэхэд бясалгалын үүрэг; донтолтын байдлаас ангижрахад бясалгалын нөлөө; сэтгэл зүйн акустик ба тарнийн бясалгалын холбоо; удаан хугацаанд дадлага хийж буй хүний субъектив туршлага; гэр бүл, нийгмийн хүрээнд майндфүлнэссийн үүрэг.

Боловсрол ба эрүүл мэнд: боловсролын ба эмчилгээний хэрэглээ; бясалгал ба анааах ухааны интегратив хандлагууд; ерөнхий болон тусгай боловсролын бясалгалын хөтөлбөрүүд; стрессийн удирдлага ба даван туулах чадвар.

Хүрээлэн буй орчин: бясалгалын орон зайд; бясалгальд зориулсан хот суурингийн архитектур; байгаль ба газар зүйн бясалгальд үзүүлэх үүрэг; бясалгалын үеийн ариун цэвэр, хооллолт ба бодисын солилцооны түвшин; удаан хугацааны бясалгалын үеийн бие махбодийн ба нойрны дэглэм.

Ёс зүй ба ухамсарын судалгаа: бясалгал судалгааны ёс зүйн асуудлууд; сэргүүн зүүд; зүүдний йог; тукдам ба үхэл; ухамсарыг судлахад EEG, fMRI болон бусад технологиудын хязгаар; ухамсар ба дээд сэтгэцийн төлөв байдал; багш, оюутны харилцааны бясалгалын практикт хүч чадлын динамик, бясалгал ба өөрчлөгдсөн төлөв байдал; майндфүлнэсийн бүтээгдэхүүнүүд; бясалгальг ашиг орлогын хэрэгсэл болгох, эрүүл мэндийн салбарт арилжааны хамтын ажиллагаа.

Илтгэл хэлэлцүүлэхээр өргөдөл гаргах хүсэлтэй хүмүүс 2025 оны 2-р сарын 28-ний дотор товч агуулгыг, 2025 оны 4-р сарын 30-ны дотор бүрэн илтгэлээ илгээх ёстай. Харин зөвхөн оролцогчоор бүртгүүлэхийг хүссэн хүмүүс www.bhutanstudies.org.bt сайтаар шууд бүртгүүлж болно. Гадаадын оролцогчдын бүртгэлийн хураамж 350 ам.доллар бөгөөд энэ нь хурлын 4 өдрийн хоол, хүлээн авалтад зориулагдана. Төлбөрийг viz гарахаас өмнө төлөх шаардлагатай.

Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл bhomedcon@gmail.com

хаягаар холбогдох эсвэл www.bhutanstudies.org.bt сайтаар зочлоорой.

ХУРАЛД ОРОЛЦОХ ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Чухал хугацаа

1. Оролцогчдыг бүртгэх: 2025 оны 3-р сарын 25 хүртэл
2. Хураангуй илтгэлийн хүлээн авах хугацаа: 2025 оны 2-р сарын 28 хүртэл
3. Виз хүсэх хугацаа: 2025 оны 3-р сарын 31 хүртэл
4. Хураангуй илтгэлийн хариу мэдэгдэх хугацаа: 2025 оны 3-р сарын 15
5. Бүрэн илтгэлийг хүлээн авах хугацаа: 2025 оны 4-р сарын 30

Бүртгэл

1. Бүртгэлийг хуралд зориулсан вэб хуудсаар дамжуулан хийнэ.
2. Олон улсын бүх оролцогчид хуралд оролцохын тулд 350 ам.долларын хураамж төлнө. Хураамж төлснөөр таны бүртгэл баталгаажна.
3. Бүртгэл дуусах хугацаа: 2025 оны 3-р сарын 25

Хураангуй илтгэл

1. Илтгэл нь дээр дурдсан сэдвийн хүрээнд байх шаардлагатай.
2. Зөвхөн анхдагч бүтээл хүлээн авна, өөр газар нийтлэгдээгүй, танилцуулагдаагүй байх ёстой.
3. Хураангуй дараах мэдээллийг багтаана: Гарчиг, зохиогчдын нэр болон харьялал, үндэслэл, зорилго, арга зүй, гол үр дүн, дүгнэлт (APA загвараар). Хураангуйн хэмжээ 300 үгнээс хэтрэхгүй байна.
4. Англи юм уу Дзонка/Чонкей хэл дээр бичиж болно.
5. Хураангуй илтгэлийг хүлээн авах хугацаа: 2025 оны 2-р сарын 28 хүртэл.
6. Хураангуйг 3-аас доошгүй гишүүнтэй баг хянан үзнэ.
7. Хүлээн авсан эсэх талаарх мэдэгдлийг 2025 оны 3-р сарын 15-ний дотор имэйлээр илгээнэ.
8. Нэг илтгэл 2-оос илүүгүй зохиогчтой байж болно.
9. Хүлээн зөвшөөрөгдсөн хураангуйг хуралд оролцогчдод урьдчилан тараах танилцуулгад оруулна.

Бүрэн илтгэл

1. Бүрэн илтгэлийг APA загварын дагуу бэлтгэнэ.
2. Бүрэн илтгэлийн хүлээн авах хугацаа: 2025 оны 4-р сарын 30 хүртэл.
3. Илтгэлийг цаг тухайд нь өгөөгүй, дутуу хүлээлгэн өгсөн, юм уу хураангуйгаас ихээхэн зөрүүтэй байвал хүчингүй болж болзошгүй.
4. Таны илтгэлийн эцсийн хувилбарыг хурал дууссанаас хойш хоёр сарын дотор хурлын эмхэтгэлд хэвлүүлэхээр ирүүлэх шаардлагатай.

Виз

1. Оролцогчдыг Бутаны Засгийн газрын албан ёсны зочин болгон хүлээн авах тул 100 ам.долларын Тогтвортой хөгжлийн хураамжаас чөлөөлнө.
2. Энэтхэг, Бангладеш, Малдивийн иргэдээс виз шаардахгүй.

3. Хамаарал бүхий хүмүүс, эхнэр/нөхөр, юм уу хамтрагчдад хуралд оролцох виз олгохгүй.
4. Энэ зорилгоор олгогдох визийн хамгийн урт хугацаа нь Бутанд 10 шөнө байрлах боломжтой.
5. Маршрутаар зорчих зөвшөөрөл олгохгүй. Паро болон Тимпугаас гадна аялал хийхэд маршрутаар зорчих зөвшөөрөл шаардлагатай.
6. Виз хүсэгчид паспортын хуулбар болон визийн өргөдлийн маягт өгнө. (Маягтыг эндээс татаж авна: <https://www.mfa.gov.bt/wp-content/uploads/2014/07/bhutan-visa-application-form.pdf>)
7. Визний өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа нь 2025 оны 3-р сарын 31 байна.
8. Визний зөвшөөрлийг и-мэйлээр илгээнэ, оролцогчид үүнийг хэвлэж авч явах шаардлагатай.
9. Та нэвтрэх цэг дээр визээ харуулах шаардлагатай болно. Та нэвтрэх цэг дээр визний зөвшөөрлийн цаасан хуулбарыг биедээ авч явах ёстой.

Илтгэгчдийн ложистик

1. Илтгэгчдэд хурал явагдах 4 өдрийн хугацаанд байр, хоол, тээврээр үйлчилнэ.
2. Хурлаас бусад хугацаанд ирж, буцах болон бусад зохицуулалтыг өөрсдөө хийнэ.

Хуралд илтгэл тавихгүй оролцогчид

1. Оролцогчдын CV хүлээн авсны дараа виз боловсруулах үйл явц эхэлнэ.
2. Хэрэв зохион байгуулах хороо таны Бутанд ирэх үндсэн зорилго нь хуралд оролцох биш гэж үзвэл зохион байгуулагч таны визийг боловсруулахгүй эсвэл цуцлах эрхтэй.
3. Оролцогчид байр, хоол, тээврээ өөрсдөө зохицуулна. Хурлын үеэр зөвхөн өдрийн хоол, цай, кофены завсарлагаар хоол өгнө.

Хурлын үеэрх хоол

1. Хурлын бүх өдрийн турш оролцогчдод өдрийн хоол, цай, кофе өгнө.
2. 2025 оны 6-р сарын 2-ны орой Бутаны Засгийн газраас олон улсын болон дотоодын оролцогчдод зориулан хүлээн авалтын зоог барина.